Эрүүл мэндийн яамны
2026 оны 4-р сарын 22-ны өдрийн
3/1796 дугаар албан бичгийн хавсралтын дагуу

# ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВД 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛСЭН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2026.06.15 Улаанбаатар хот

<table>
<tr><th>№</th><th>Хэрэгжүүлэх арга хэмжээ</th><th>Хэрэгжүүлсэн ажил</th><th>Нотлох баримт</th></tr>
<tr><td>1</td><td>Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, үнэлгээ хийж, олон нийтэд ил тод мэдээлнэ.<br><br>gemtel.mn цахим хуудсанд 13 ажлын байрны 19 удаагийн зар; zangia.mn цахим хуудсанд 4 ажлын байрны 4 удаагийн зар; Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Facebook page хуудсанд 6 ажлын байрны 17 удаагийн зар тус тус байршуулсан.<br><br>Ингэснээр тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 17 ажлын байранд 40 удаагийн зар мэдээллийг олон нийтэд хүргэж, сонгон шалгаруулалтад шаардлагатай хүний нөөцийг татан оролцуулах арга хэмжээг зохион байгуулсан байна.</td><td>Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор мэдээллийн ил тод байдлын самбарыг байршуулан, иргэд болон үйлчлүүлэгчдэд шаардлагатай мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулж ажиллаж байна.<br><br>• shilendans.gov.mn<br>• shilen.gov.mn сайтууд<br>• gemtel.mn вэб хуудас<br>• Гэмтэл согог судлалын үндэсний төв ФБ хуудас зэрэг олон сувгаар Санхүүгийн мэдээлэл, Хүний нөөцийн сонгон шалгаруулалт, ажлын байрны зар мэдээ мэдээлэл, Байгууллагын үйл ажиллагааны статистик мэдээлэл болон бусад холбогдох мэдээллүүдийг цаг тухай бүрд байршуулан ажиллаж байна.</td><td>





Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв
2 April
АЖЛЫН БАЙРНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА...
Салбартаа тэргүүлэгч хүний нөөцийн баг бүрэлдэхүүн
Удирдлагын шилдэг менежмент
Ажлын байрны зөв зохион байгуулалт
Цалин урамшууллын таатай нөхцөл
Нийгмийн хамгааллын оновчтой шийдлүүд
Эрүүл, аюулгүй, тав тухтай орчин
Хувь хүний хөгжил, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх алтан боломжууд таныг хүлээж байна.
Та бүхэн доорх QR кодоор нэвтрэн ажил горилогчийн анкет бөглөх болон лавлах утсаар холбогдоно уу.
https://docs.google.com/.../1FAIpQLSfpeL_u632M2u.../viewform See less
</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | | |     |
| 2 | Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар эрүүл мэндийн ажилтнуудад сурталчилна. | Авлига ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх зорилгоор холбогдох мэдээллийг өгөх талаар “Шударга ёс хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар болон Гэмтэл согог судлалын үндэсний ФБ хуудсаар мэдээлэл өгч байна. |    |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td>


</td></tr>
</table>

<table>
<tr>
<td>3</td>
<td>Салбарын хэмжээнд сул орон тоонд хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалт зарлах, хууль бус “түр орлон гүйцэтгэгч” томилохыг зогсоох</td>
<td>ГССҮТөвийн хэмжээнд сул орон тоонд хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалт зарлах, хууль бус “түр орлон гүйцэтгэгч” томилох ажиллагаа хийгдээгүй.</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>4</td>
<td>Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд бүрийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулж, дүгнэлт гарсаны дараа томилгоог баталгаажуулах</td>
<td>2026 оны эхний хагас жилд 12 ажил албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэнийг 100% бүрэн ХАСУМ хянуулж, дүгнэлт гарсаны дараа захирлын тушаал гарч, баталгаажуулсан байна.<br><br>• Эмнэлзүй хариуцсан дэд захирал – 1;<br>• Тасгийн эрхлэгч – 6;<br>• Хүний нөөцийн менежер – 2;<br>• Эрсдэл, аюулгүй байдал хариуцсан менежер – 1;<br>• Чанарын менежер – 1<br>• Албаны дарга – 1<br><br>Эрсдэл, аюулгүй байдал хариуцсан менежерийн мэдүүлэгт алдаа гарч дахин мэдүүлсэн тул 13 мэдүүлгийн жагсаалт харагдаж байгаа.</td>
<td><br>ХАСУМ жагсаалт (13) + Шинээр үүсгэх<br>
<table>
<tr><th>№</th><th>Мэдүүлэг гаргагч</th><th>Үндэслэл</th></tr>
<tr><td>1</td><td>Э. Номин-Эрдэнэ</td><td>Шинээр томилогдох</td></tr>
<tr><td>2</td><td>Э. Номин-Эрдэнэ</td><td>Шинээр томилогдох</td></tr>
<tr><td>3</td><td>С. Гансүх</td><td>Түр орлон гүйцэтгэгч</td></tr>
<tr><td>4</td><td>Т. Отгонболд</td><td>Шинээр томилогдох</td></tr>
<tr><td>5</td><td>Ц. Эрдэнэ</td><td>Шинээр томилогдох</td></tr>
<tr><td>6</td><td>Д. Бат-Эрдэнэ</td><td>Шинээр томилогдох</td></tr>
<tr><td>7</td><td>Б. Эрдэнэболд</td><td>Шинээр томилогдох</td></tr>
<tr><td>8</td><td>Б. Урангоо</td><td>Шинээр томилогдох</td></tr>
<tr><td>9</td><td>З. Энхмандах</td><td>Шинээр томилогдох</td></tr>
<tr><td>10</td><td>Б. Мөнгөнцэцэг</td><td>Албан тушаалын ангилал, зэрэглэл өөрчлөгдсөн</td></tr>
<tr><td>11</td><td>Э. Саруул</td><td>Албан тушаалын ангилал, зэрэглэл өөрчлөгдсөн</td></tr>
<tr><td>12</td><td>Т. Номинтуяа</td><td>Шинээр томилогдох</td></tr>
<tr><td>13</td><td>Г. Юмчмаа</td><td>Шинээр томилогдох</td></tr>
</table>
</td>
</tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| 5 | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд өөрийн болон хамаарал бүхий этгээдийн байгууллага руу өвчтөн чиглүүлэх үйл ажиллагаанд ёс зүйн хяналт тавих | ГССҮТөвийн захирлын тушаалаар байгуулагдсан худалдах, худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулах үнэлгээний хороо ажилладаг ба сүүлийн 2 жил эдгээр хорооны үйл ажиллагаанд үнэлгээ хийх ажлын хэсэг гарч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br><br>2025 оны А/141 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэг 2025 оны 600 гаруй худалдан авах гэрээнд хяналт хийж, тайланг нэгтгэн, үр дүнг танилцуулсан. 2026 оны гэрээ дүгнэх үйл ажиллагаа оны сүүлээр хийгдэнэ. | ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН<br>ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН<br>ТУШААЛ<br><br>2025 оны 10 сарын 13 өдөр Дугаар А/141 Улаанбаатар хот<br><br>Ажлын хэсэг байгуулах тухай<br><br>Иргэний хуулийн 243 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам", Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:<br><br>1.Төсвийн хөрөнгө оруулалт болон батлагдсан төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэрийн хөрөнгөөр худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгсэл, мэс заслын имплант хэрэгсэл худалдан авалтын гүйцэтгэлийг хянах, хүлээн авах, гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, эмнэлгийн тусламж үйлчилгээний машин, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авалтын гүйцэтгэлийг хянах, хүлээн авах, гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад шаардлагатай ажил, үйлчилгээ, бараа, материал, бусад хэрэглэл худалдан авалтын гүйцэтгэлийг хянах, хүлээн авах, гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.<br><br>2.Төвийн 2025 оны худалдан авалтын гүйцэтгэлийг холбогдох хууль, тогтоол, журам, зааварт нийцүүлэн хянаж, хүлээн авч, гэрээг дүгнэн, гүйцэтгэл, үр дүнг 2025 оны 11 сарын 04-ний дотор тайлагнан ажиллахыг ажлын хэсгийн дарга (Б.Мөнхдөл, Б.Ганчимэг, Б.Түмэн-Өлзий) нарт, гүйцэтгэлийн баримт бичгийг үндэслэн төлбөр тооцоог хийж, бий болсон хөрөнгийг данс, бүртгэлд тусган ажиллахыг Санхүү бүртгэлийн албаны дарга (Ц.Энхбаяр)-т тус тус үүрэг болгосугай.<br><br>3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал (Б.Батзориг)-т даалгасугай.<br><br>ЗАХИРАЛ Э.ГАЛБАДРАХ<br><br>1025011845<br>e:/my doc/2025/тушаал |
| 6 | Ажилчдын шагнал, урамшууллыг бэлнээр эргүүлэн татах, зориулалтын бусаар (ойн баяр гэх мэт) зарцуулахыг таслан зогсоох, санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах | Эрх бүхий байгууллагын дүгнэлтээр илэрсэн санхүүгийн зөрчлийн дүгнэлт гараагүй. | Ажилчдын шагнал, урамшууллыг бэлнээр эргүүлэн татах, зориулалтын бусаар (ойн баяр гэх мэт) зарцуулахыг таслан зогсоох санхүүгийн зөрчлийн дүгнэлт гараагүй. |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | Удирдах ажилтан болон эмнэлгийн мэргэжилтнүүдэд Авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол сургалт зохион байгуулах | ГССҮТөвийн захирал, дэд захирлууд, тасгийн эрхлэгч, албадын дарга, ахлах сувилагч, менежерүүдэд “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” түүнд заасан хориглолт хязгаарлалтуудын талаар таниулах эрх зүйн мэдлэг олгох сургалт зохион байгуулж, захирал, дэд захирлууд, тасаг нэгжийн эрхлэгч, дарга нараар баталгаа гаргуулав.<br><br>Тасгийн эрхлэгч, албадын дарга, ахлах сувилагч нарт болон нийт эмч нарт 2 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 115 ажилтан хамрагдаж, удирдах 44 албан тушаалтан баталгаа гаргасан байна. | <br> |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | Байгууллага бүр төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, тендерийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу цаг тухайд нь мэдээлэх | 2026 оны I улирлын байдлаар Шилэн дансны мэдээллийн ил тод байдлын үнэлгээ:<br>• Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал – 96.23 хувь;<br>• Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал – 95.12 хувь;<br>• Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал – 100 хувь;<br>• Үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал – 100 хувь;<br>• Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал – 97.81 хувь<br><br>Нийт үзүүлэлтийн дунджаар байгууллагын нэгдсэн үнэлгээ 97.73 хувиар дүгнэгдсэн байна. | <br><br> |

<table>
<tr>
<td>9</td>
<td>Эрүүл мэндийн салбарын шударга байдлын үнэлгээг 2026 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэх<br><br>Төлөвлөгөөнд 12 ажил төлөвлөснөөс эхний хагас жилд 10 ажлыг хэрэгжүүлж, хэрэгжилтийн хувь 83.3% байна. Хоёрдугаар хагас жилд үлдсэн ажлыг бүрэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.</td>
<td>2026 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 1/1303 дугаар албан бичгээр ирүүлсэн эрүүл мэндийн салбар дахь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилготой "Салбарын шударга байдлын үнэлгээг 2026 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө"-г баримтлан тус төвд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлж, хэрэгжилтийн тайланг 2026 оны 6 сарын 10-ны өдөр ЭМЯаманд илгээсэн.</td>
<td><br>БАТЛАВ<br>ЗАХИРАЛ Э.ГАЛБАДРАХ<br>ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ<br>2026.03.24
<table>
<tr><th>№</th><th>Хэрэгжүүлэх арга хэмжээ</th><th>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</th><th>Зорилтот түвшин</th><th>Хэрэгжүүлэх хугацаа</th><th>Хариуцах албан тушаалтан</th></tr>
<tr><td>1</td><td>Байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар дахь үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны мэдээлэл ил тод эсэхэд улирал тутам дүн шинжилгээ хийх, дутуу мэдээллүүдийг байршуулах арга хэмжээ авах</td><td>Хувь</td><td>80 хувь %</td><td>2026.03.10-2026.12.31</td><td>Мэдээлэл технологийн алба<br>Хэвлэлийн дизайнер<br>Санхүү бүртгэлийн алба<br>Хүний нөөцийн алба</td></tr>
<tr><td>2</td><td>Байгууллагаас хэрэгжүүлсэн авлигын эсрэг арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчин, олон нийтэд сурталчлах</td><td>Хэвлэл мэдээллийн хэрэгсэл цахим орчинд түгээсэн мэдээллийн тоо, зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгийн тоо</td><td>- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр улирал бүр 3-аас доошгүй мэдээлэл гарсан байна<br>- 2-оос доошгүй удаа нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан байна<br>- Олон нийтийн цахим сүлжээ /фейсбүүк, ютүб, твиттер, инстаграмм, цахим хуудас/ зэрэгт тухай бүр мэдээлэл байршуулсан байна</td><td>2026.03.10-2026.09.30</td><td>Хэвлэлийн дизайнер<br>Хэвлэл мэдээллийн ажилтан</td></tr>
<tr><td>3</td><td>Олны танил хүмүүсээр байгууллагын үйл ажиллагааг сурталчилуулсан зэрэг бичлэг, сэтгүүл, пост мэдээлэл цахим системд оруулах зэрэг нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах</td><td>Хамтран ажилласан олны танил хүний тоо, хийлгэсэн сурталчилгааны тоо</td><td>Олны танил 5-аас доошгүй хүмүүсээр байгууллагын сурталчилгаа хийлгэсэн байх</td><td>2026.03.10-2026.09.30</td><td>Хэвлэлийн дизайнер<br>Хэвлэл мэдээллийн ажилтан</td></tr>
</table>
</td>
</tr>
<tr>
<td>10</td>
<td>Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, дүгнэлтэд тусгагдсан зөрчлийг арилгах төлөвлөгөөг тухай бүр гарган, хэрэгжилтийг бүрэн хангаж, тайланг Авлигатай тэмцэх газар болон Эрүүл мэндийн яаманд хүргүүлэх</td>
<td>2026 онд АТГазраас мөрдөгчийн мэдэгдэл ирсэн 2 тохиолдолд холбогдох эмч нарт хариуцлага тооцсон ба мөрдөгчийн мэдэгдлийн дагуу ажил зохион байгуулж, тайланг АТГазарт хүргүүлсэн.<br><br>• Мөрдөгчийн мэдэгдэл 2<br>• Хариуцлага тооцсон ажилтан 2<br>• Мэдэгдлийн дагуу зохион байгуулсан ажлын тайлан илгээсэн 2</td>
<td><br>ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ<br>2026.05.12 № 01/529<br>АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН МӨРДӨН ШАЛГАХ ХЭЛТЭСТ<br><br>Хариу хүргүүлэх тухай<br><br>Танай байгууллагын 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 06/6337 дугаартай албан бичиг, Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай №39 дугаартай мөрдөгчийн мэдэгдлийн дагуу зохион байгуулан хэрэгжүүлж байгаа ажлын мэдээллийг хүргүүлж байна.<br><br>Хүндэтгэсэн<br>ЗАХИРАЛ Э.ГАЛБАДРАХ</td>
</tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| 11 | Эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлэгч төвтэй, хүндэтгэлтэй харилцаа, ёс зүйд суурилсан чанартай тусламж, үйлчилгээний соёлыг төлөвшүүлэх хүрээнд “Хүндэтгэлтэй харилцаа – Чанартай тусламж” аян зохион байгуулах | Албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг төлөвшүүлэх, үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээний соёлыг бэхжүүлэх чиглэлээр тайлант хугацаанд нийт 4 удаагийн сургалт зохион байгуулж, 141 албан хаагчийг хамруулсан.<br>Үүнд:<br>✓ 2026 оны 01 дүгээр сард Ёс зүйн салбар хорооны гишүүн С.Наранбаатар “Ёс зүй, харилцаа хандлага” сэдвээр сургалт зохион байгуулж, 45 асрагч, үйлчилгээний ажилтан хамрагдсан.<br>✓ 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Төв эмнэлэгт Ёс зүйн хорооны гишүүн Г.Бадамгарав “Ёс зүй, харилцаа хандлага” сэдвээр сургалт зохион байгуулж, 30 албан хаагч хамрагдсан.<br>✓ 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Салбар эмнэлэгт Ёс зүйн хорооны гишүүн Д.Дэлгэр “Ёс зүй, харилцаа хандлага” сэдвээр сургалт зохион байгуулж, 30 туслах сувилагч хамрагдсан.<br>✓ 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Үндэсний сургагч багш А.Амаржаргал “Эерэг хандлага” сэдвээр сургалт зохион байгуулж, 36 албан хаагч хамрагдсан. | <br> |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | Авлига, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах олон сувгийн (утас, цахим, саналын хайрцаг) тогтолцоог бүрдүүлж, мэдээлэгчийн нууцлалыг ханган шуурхай шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах | Авлига, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах 1110 утасны дугаарыг gemtel.mn вэб хуудас, Гэмтэл согог судлалын үндэсний төв ФБ хуудас зэрэгт байршуулсан ба ЭМТҮЧАБАлбанд бичгээр хүлээн авч байна. Мөн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд авлига, ёс зүйн зөрчлийн талаар асуулт оруулсан.<br><br>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанд ирсэн өргөдөл, гомдлын агуулгыг хувиар илэрхийлбэл:<br>• Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой 34 буюу 68%<br>• Эмч, ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа, хандлагатай холбоотой 10- буюу 20%<br>• Битүүмжтэй холбоотой 2 буюу 4%<br>• Цаг авах, цуцлах, цаг захиалгын утастай холбоотой 2 буюу 4%<br>• Бусад 2 буюу 4% байсан ба авлига ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой мэдээлэл эхний хагас жилд бүртгэдээгүй. | <br><br><br> |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг байгууллагын албан ёсны цахим хуудас, сошиал суваг, дотоод сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн самбар зэрэгт байрлуулж олон нийтэд хүргэх, “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах | АТГазраас бүтээсэн видео шторк болон зурагт хуудас зэргийг “Гэмтэл согог судлалын үндэсний төв” ФБ хуудсанд тогтмол байршуулж, нийтэд сурталчилж байна.<br><br>Авлига ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх мэдээллийн түгээлтийн үзүүлэлт:<br>• Хүрсэн хүний тоо 3,6 сая<br>• Хүрсэн хүний тоо 1,3 сая<br>Авлигыг мэдээлэх утас болон олны танил хүмүүсийн сурталчилгааны түгээлтийн үзүүлэлт:<br>• Хүрсэн хүний тоо 1,4 сая<br>Хүрсэн хүний тоо 1,1 сая<br><br>Мөн “Шударга ёс хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар болон төвийн хэмжээнд бүх тасаг нэгжүүдийн коридорт 15 цахим дэлгэцээр мэдээлэл түгээж байна. |       |

| | | | |
|---|---|---|---|
| 14 | Харьяа удирдах шатны байгууллагаас ирүүлсэн чиглэлийн дагуу байгууллагад хэрэгжүүлэх Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг журамд заасан хугацаанд тайлагнах | Эрүүл мэндийн яамны 2026 оны 4-р сарын 22-ны өдрийн 3/1796 дугаар албан бичгээр ирүүлсэн Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баримтлан ГССҮТөвд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөнд 14 ажил төлөвлөснөөс эхний хагас жилд бүрэн хэрэгжсэн ба тайланг заасан хугацаанд нэгтгэж, Эрүүл мэндийн яаманд илгээсэн. |  |

Эрүүл мэндийн яамны
2026 оны 4-р сарын 22-ны өдрийн
3/1796 дугаар албан бичгийн хавсралт

БАТЛАВ ЗАХИРАЛ
Э.ГАЛБАДРАХ

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 оны дөрөвдүгээр сарын 24 Улаанбаатар хот

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|---|---|
| 1 | Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, үнэлгээ хийж, олон нийтэд ил тод мэдээлнэ | Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулсан тоо | Нээлттэй болгохоор хууль, журамд заасан мэдээллийг цахим системд байршуулсан байна | 2026.04.10-2026.12.01 | Мэдээлэл технологийн алба<br>Холбогдох нэгжийн удирдлагууд |
| 2 | Шүгэл үлээгчийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар эрүүл мэндийн ажилтнуудад сурталчилна | Шүгэл үлээгчийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар сурталчилсан хэлбэр, тоо | Сурталчилгаа явуулсан байна | 2026.04.10-2026.12.01 | Хуулийн зөвлөх<br>Дотоод хяналтын ажилтан |
| 3 | Салбарын хэмжээнд сул орон тоонд хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалт зарлах, хууль бус "түр орлон гүйцэтгэгч" томилохыг зогсоох | Холбогдох хууль, журмын дагуу хийсэн томилгооны тоо | Холбогдох хууль, журмын дагуу томилгоо хийсэн байна | 2026.04.10-2026.12.01 | Хүний нөөцийн алба |
| 4 | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд бүрийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулж, дүгнэлт гарсны дараа томилгоог баталгаажуулах | АТГ-ын хяналтад хамрагдсан томилгооны хувь | Тухай бүр АТГ-т ХАСУМ-ийг хянуулсан байна | 2026.04.10-2026.12.01 | Хүний нөөцийн алба<br>ЭБАТ |
| 5 | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд өөрийн болон хамаарал бүхий этгээдийн байгууллага руу өвчтөн чиглүүлэх үйл ажиллагаанд өс зүйн хяналт тавих | Хяналт хийсэн тайлан | Хяналтаар гарсан зөрчлийг арилгасан байна | 2026.04.10-2026.12.01 | Дотоод хяналтын ажилтан<br>Хуулийн зөвлөх |

Тайлан бичиж, нэгтгэсэн:
Эрх бүхий албан тушаалтан Б.Түмэн-Өлзий

Тайлан бичсэн:
Санхүү бүртгэлийн албаны дарга Ц.Энхбаяр
Хүний нөөцийн албаны дарга А.Цэрэндолгор
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга Б.Бат-Оргил
Эдийн засаг төлөвлөлт маркетингийн албаны хэвлэлийн дизайнер Б.Нарангэрэл

Тайлан хянасан:
Захирал Э. Галбадрах

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ ТБАГ
УЛААНБААТАР ХОТ
ХТҮ6970 9024041591 9077219